



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН
ГАЗАР

Хүн амын төрөлт, нас баралт, өвчлөлийн МЭДЭЭЛЭЛ


2022 оны 11 дүгээр сарын байдлаар

Мөрөн сум

ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

ТӨРӨЛТ

Аймгийн хэмжээнд 2022 оны эхний 11 сарын байдлаар 2089 эх амаржсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 383 тохиолдол буюу 15.5%-иар буурсан байна. Төрөлт Баянзүрх, Жаргалант, Их-Уул, Түнэл, Чандмань-Өндөр, Эрдэнэбулган сумдад өсч бусад сумдад өмнөх оны мөн үеэс буурсан үзүүлэлттэй байна. Нийт төрсөн эхчүүдээс 6 ба түүнээс дээш удаа хяналтад хамрагдсан хамрагдалтын хувь 69.7% байна.





ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

Аймгийн хэмжээнд 2022 оны эхний 11 сарын байдлаар нийт 2096 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 382 тохиолдолоор буурсан байна. Амьд төрсөн хүүхдийн 3,8 хувь /79/ нь бага жинтэй буюу 2500 гр-аас доош жинтэй төрсөн байна. Төрөөд нэг цагийн дотор хөхөө амласан хүүхдийн хувь 96,2 хувь байна. 5 хүртэлх насны хүүхдийн өсөлт хөгжлийн хяналтанд 2022 оны эхний 11 сард нийт 57440 хүүхэд жинлэж, жинлэсэн хүүхдийн 0.1 хувь нь туранхай, 0,1 хувь нь тураалтай, 0,1 хувь нь өсөлтийн хоцрогдолтой байна. 38.2 хувь нь А амин дэм, 56.5 хувь нь Д амин дэм, 6.6 хувь нь олон найрлагат бичил тэжээл хэрэглэсэн байна.

НЯЛХАСЫН ЭНДЭГДЭЛ

Аймгийн хэмжээнд 2022 оны эхний 11 сарын байдлаар нялхсын эндэгдлийн 34 тохиолдол бүртгэгдсэн нь 2021 оны мөн үеэс 2 тохиолдлоор буурч, 1000 амьд төрөлтөнд 16.2 ногдож байна. Нялхсын эндэгдлийн 50.0 хувийг нярайн эндэгдэл эзэлж байгаа бөгөөд 1000 амьд төрөлтөд 8.1 байна. Нийт 25 тохиолдол буюу 73.5 хувь нь эмнэлэгт эндсэн бөгөөд 20 нь эрэгтэй хүүхэд байна.

Нялхсын эндэгдлийг шалтгаанаар нь авч үзвэл:



1-5 НАС ХҮРТЭЛХ ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ

2022 оны эхний 11 сарын байдлаар 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 4 тохиолдол бүртгэгдсэн ба өнгөрсөн оны мөн үеэс 6 тохиолдлоор буурсан байна. 1000 амьд төрөлтөнд 1.9 ногдож байна. Хүүхдийн эндэгдлийг оношоор нь авч үзвэл дотоод шүүрэл, тэжээлийн ба бодисын солилцооны эмгэг 1, амьсгалын тогтолцооны эмгэг 1, осол гэмтлийн шалтгаант нас баралтын 2 тохиолдол бүртгэгдсэн байна.



НАС БАРАЛТЫН ҮЗҮҮЛЭЛТ


2022 оны эхний 11 сарын байдлаар 712 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 27 тохиолдолоор буурсан байна. Нийт нас баралтын 22,1 хувь нь эмнэлэгт нас барсан ба үүнээс 25,5 хувь нь хоног болоогүй нас баралт байна. Осол гэмтлийн нас баралт 114 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 19 тохиолдолоор өссөн, нийт нас баралтын 16,0 хувийг эзэлж, 10000 хүн амд 8,3 ногдож байна. Хорт хавдрын нас баралт 179 тохиолдол бүртгэгдсэн ба өнгөрсөн оны мөн үеэс 14 тохиолдлоор өсч, нийт нас баралтын 25,1 хувийг эзэлж, 10000 хүн амд 13,1 ногдож байна.



Нийт нас баралтын тэргүүлэх шалтгаан: /10000 хүн амд/

1. Цусны эргэлтийн тогтолцооны өвчин- 19.5
2. Хавдар-13.1
3. Гадны шалтгаант өвчлөл- 8.3
4. Амьсгалын тогтолцооны өвчин-3.0
5. Хоол боловсруулах тогтолцооны эмгэг-2.7

Осол гэмтлийн шалтгаант нас баралт,
2022 оны эхний 11 сарын байдлаар




Аймгийн хэмжээнд 2022 оны эхний 11 сарын байдлаар нийт эдийн шинжилгээ 957, эсийн шинжилгээ 5278 хийгдсэн байна. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт нийт 108 нас баралт буюу 50.0% эмгэг судлалын задлан шинжилгээ хийгдэж үндсэн оношийн зөрүү 2 бүртгэгдсэн байна. Задлан шинжилгээ хийгдээгүй нас баралт 54 тохиолдол байна.


АМБУЛАТОРИ СТАЦИОНАРИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ

Аймгийн хэмжээнд 2022 оны эхний 11 сарын байдлаар амбулаторид нийт 490691 үзлэг хийгдсэнээс 35.7 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг, 50.2 хувийг өвчний учир амбулаторид, 8.0 хувийг идэвхитэй хяналтын үзлэг, 4.1 хувийг гэрийн идэвхитэй үзлэг, 2.1 хувийг гэрийн дуудлагын үзлэг эзэлж байна.

Амбулаторийн үзлэгийн төрөл




Амбулаторийн үзлэг,
2021-2022 оны эхний 11 сарын байдлаар



ЖИРЭМСЭНИЙ ХЯНАЛТ

Шинээр хяналтанд авсан нийт 2113 жирэмсэн эмэгтэйчүүдээс 89.4 хувь нь жирэмсний эрт үедээ хяналтанд хамрагдсан байна. Цусны шинжилгээнд 94.0 хувь нь хамрагдаж, 1.2 хувь нь цус багатай гарсан байна. Эхний 11 сарын байдлаар жирэмсний хяналтанд шинээр орсон эхчүүдээс трихомониаз, заг хүйтэн илрүүлэх шинжилгээнд 94.2 хувийг, тэмбүү илрүүлэх шинжилгээнд 95.3 хувийг, ХДХВ илрүүлэх шинжилгээнд 94.8 хувийг тус тус хамруулж заг хүйтэн-56, трихомониаз-19, тэмбүү-33 тохиолдлыг тус тус бүртгэн эмчилсэн байна.



ХАЛДВАРТ БУС ӨВЧИН

2022 оны эхний 11 сарын байдлаар халдварт бус өвчлөл 117605 тохиолдол бүртгэгдсэн ба өнгөрсөн оны мөн үеэс 46723 тохиолдлоор буурсан байна. 10000 хүн амд 8594.2 байгаа ба осол гэмтлийн өвчлөл 1577 бүртгэгдэж, нийт халдварт бус өвчний 1,3 хувийг эзэлж, 10000 хүн амд 115.2 байна.

Амбулаторийн өвчлөлийн тэргүүлэх шалтгаан: /10000 хүн амд/




1. Цусны эргэлтийн тогтолцооны өвчин- 2030.9
2. Амьсгалын эрхтэн тогтолцооны өвчин-1934.0
3. Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчин- 1468.0
4. Шээс бэлгэсийн тогтолцооны эмгэг-734.2
5. Нүд ба түүний дайврын тогтолцооны өвчин-637.7


Стационарт нийт 27350 хүн хэвтэж эмчлүүлсэн ба дундаж ор хоног 6.8, орны эргэлт 28.6, орны фонд ашиглалт 194.4, фонд ашиглалтын хувь 64.3 байна.Тосонцэнгэл, Түнэл орны фонд ашиглалт аймгийн дунджаас дээгүүр, бусад газруудад доогуур хувьтай байна.

Аймгийн хэмжээнд 2022 оны эхний 11 сарын байдлаар нийт 18333 түргэн тусламжийн дуудлага хүлээж авч гүйцэтгэснээс 18,3 хувь /3346/ нь алсын дуудлага, 3,3 хувь /598/ нь осол гэмтлийн дуудлага байна. 1 өдөрт дунджаар аймгийн хэмжээнд 55.6 дуудлага, АНЭ 19.6 дуудлага тус тус хүлээн авч гүйцэтгэжээ.

ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ ЭРТ ИЛРҮҮЛЭГ ҮЗЛЭГИЙН МЭДЭЭЛЭЛ

2022 оны эхний 11 сарын байдлаар артерийн гипертензи эрт илрүүлгийн үзлэгт нийт 62060 хүн анх хамрагдаж, хамрагдвал зохих хүн амын 70.9 хувийг эзэлж байна. Нийт үзлэгт хамрагдсан хүний 44.7% эрэгтэй, 55.3% нь эмэгтэй байна. Давтан үзлэгт 10206 хүн хамрагдсан ба үүнээс оношлогдсон артерийн гипертензи 2205 буюу 21.6% нь онош баталгаажсан байна. Чихрийн шижин өвчний эрт илрүүлгийн үзлэгт нийт 42055 хүн анх хамрагдаж, хамрагдвал зохих хүн амын 81.0 хувийг эзэлж байна. Нийт үзлэгт хамрагдсан хүний 43.9% эрэгтэй, 56.1% нь эмэгтэй байна. Давтан үзлэгт 1351 хүн хамрагдсан ба үүнээс оношлогдсон 56 буюу 4.1% нь онош баталгаажсан байна.





ӨРХИЙН ЭМТ-ИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Өрхийн ЭМТ нийт үзлэг 94936 байгаа ба үзлэгийн төрлөөр нь авч үзвэл:

- Урьдчилан сэргийлэх үзлэг 48.7 хувь
- Өвчний учир үзлэг 28.6 хувь
- Диспансерийн хяналт 15.5 хувь
- Гэрийн идэвхитэй эргэлт 6.6 хувь
- Гэрийн дуудлага 0.6 хувийг тус тус эзэлж байна.

Халдварт бус өвчний 13781 тохиолдол бүртгэгдэж, 5 хүртэлх насны хүүхдийн амьсгалын замын цочмог өвчин 7.1 хувийг, 5 хүртэлх насны хүүхдийн халварт бус суулгалт 0.4 хувийг тус тус эзэлж байна.

Шинээр хяналтанд авсан 744 жирэмсэн эмэгтэйдгээс 86.8 хувийг эрт үед нь хяналтанд авч 100 хувийг цусны шинжилгээнд хамруулсан байна.

Нийт 204 нас баралт бүртгэгдсэн ба Аймгийн Нэгдсэн Эмнэлэгт 62 тохиолдол байна. Хорт хавдрын нас баралт 60, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 10 тохиолдол бүртгэгдсэнээс аймгийн нэгдсэн эмнэлэгт 7 тохиолдол бүртгэгдсэн байна.

ХУВИЙН ЭМНЭЛГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Хувийн эмнэлгүүд нийт 26478 үзлэг хийснээс

- Урьдчилан сэргийлэх үзлэг 4.0 хувь
- Диспансерийн хяналт 2.8 хувь
- Өвчний учир үзлэг 93.2 хувийг тус тус эзэлж байна.

Стационариар нийт 7021 хүн хэвтэн эмчлэгдэж, 51790 ор хоног ашигласан ба дундаж ор хоног 7.4 орны эргэлт 25.3 ба орны фонд ашиглалт 187.0, орны фонд ашиглалтын хувь 68.0 байна. Нийт 28 халдварт бус өвчний тохиолдол бүртгэгдсэн байна. Халдварт бус өвчний 37 тохиолдол, 5 хүртэлх насны хүүхдийн амьсгалын замын цочмог өвчин 17 тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.

ХАЛДВАРТ ӨВЧИН

Аймгийн хэмжээнд эхний 11 сарын байдлаар 5494 халдварт өвчний тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 401.5 ногдож байна. 2021 оны мөн үед 18864 тохиолдол, 10000 хүн амд 1397.7 ногдож байжээ. 10000 хүн амд ногдох халдварт өвчний гаралт Цагаан-Үүр, Цэцэрлэг, Шинэ-Идэр, Мөрөн суманд аймгийн дунджаас өндөр байна.

Нийт халдварт өвчнөөс БЗХӨ 17.9 хувь, сүрьеэ 1.2 хувь, амьсгалын замын өвчин 1.3 хувь, цусан халдвар 0.1 хувь, гэдэсний халдварт өвчин 0.8, арьс салтстаар халдварлах халдвар 0.1, Зоонозын болон мал амьтнаас хүнд халдварладаг өвчлөл 0.3 хувь, Ковид-19 халдвар 78.3 хувийг тус тус эзэлж байна.

ЦОЧМОГ ХАЛДВАРТ ӨВЧИН

Нийт цочмог халдварт өвчний 4508 тохиолдлоос:

- Халдварын гаралтай суулгалт 5 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор
- Ёлом 3 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 2 тохиолдлоор
- Гахай хавдар 0 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 3 тохиолдлоор
- Цусан суулга 28 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 2 тохиолдлоор
- Ковид-19 4301 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 13853 тохиолдлоор тус тус буурч
- Сальмонеллэз 2 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 2 тохиолдлоор
- Сүрьеэ 64 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 9 тохиолдлоор
- Хоолны хордлого 9 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 8 тохиолдлоор
- Хепатит А 1 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор
- Хепатит В 4 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 3 тохиолдлоор
- Хепатит С 3 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 3 тохиолдлоор
- Салхинцэцэг 66 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 47 тохиолдлоор
- Гар хөл амны өвчин 6 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 3 тохиолдлоор
- Хачигт риккеттиоз 16 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 15 тохиолдлоор тус тус өссөн үзүүлэлттэй байна.
- Өргөн дархлаажуулалт бүхий халдварт өвчнөөс халдварт саа, сахуу, хөхүүл ханиад, татран, менингококкт халдварын өвчлөл бүртгэгдээгүй байна.




ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ХАМ ШИНЖ, СЭЖИГТЭЙ ТОХИОЛДОЛ

- 2022 оны эхний 11 сарын байдлаар халдварт өвчний хам шинж, сэжигтэй, өвөрмөц 3687 тохиолдол мэдээлэгджээ. Үүнээс халууралт тууралт 17,1 хувь (62), цэврүүт тууралт 1,7 хувь (63), цусархаг суулгалт 0,7 хувь (27), шарлалттай 0,3 хувь (11), усархаг суулгалт 0,1 (4), хоолны хордлогот халдвар 0,4 хувь (16), Амьсгалын цочмог халтай хам шинж /АЦХаХ/ 95,0 хувь /3503/ тус тус бүртгэгдсэн байна.
- Нийт мэдээлэгдсэн хам шинжийн өвчлөл /бодит тоогоор/




ТОМУУ, ТОМУУ ТЕСТ ӨВЧИН


2022 оны эхний 11 сарын байдлаар аймгийн хэмжээнд ТТӨ-ий 25039 тохиолдол бүртгэгдсэн нь 10000 хүн амд 1829,8 болсон байна. Харин өнгөрсөн оны мөн үед 9543 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 707,1 болсон байна.




Томуу томуу төст өвчин, долоо хоног



Томуу, томуу төст өвчин (насны бүлэг, хувиар)





АЗЦХХ-ын хэвтэлт (насны бүлэг, хувиар)



БЭЛГИЙН ЗАМЫН ХАЛДВАРТ ӨВЧИН

Нийт халдварт өвчний дотор БЗХӨ-ний эзлэх хувь 17.9% (986) тохиолдол байгаа ба өнгөрсөн оны мөн үед 3.1% (586) тохиолдол бүртгэгдсэнээс:

- Трихомониаз 64 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 7 тохиолдлоор буурч
- Тэмбүү 143 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 2 тохиолдлоор
- Гонококк халдвар 777 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 405 тохиолдлоор тус тус өссөн байна.



Хянасан:
Дүгнэлт хийсэн:

Эрүүл мэндийн газрын дарга М.Үүрийнбаяр
Эрүүл мэндийн мэдээ, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн
П.Баярмаа